

ТУХАЙЛАХ ЯЛГАЦ ГИШҮҮН (THE) (The definite article)

1. the [kʰɪ] : гийгүүлэгчээр эхэлсэн үгийн өмнө : the book, the boy, the lady, the university, the union
2. the [ki] : эгшгээр эхэлсэн нэрийн өмнө : the American, the animal; мөн үл дуудагдах h-ээр эхэлсэн үгийн өмнө : hour, honour, honest; эхний үе нь өргөлтгүй үгийн h-ийн өмнө: the horizon тус тус хэрэглэгдэнэ.

I . Тухайлах ялгац гишүүн хэрэглэх тохиолдлууд

- Зүг чиг заасан : towards the North, in the North, гэвч: from north to south, from east to west гэх мэт тохиолдолд хэрэглэхгүй.
- Газар орон болон арлын нэр олон тоонд : the East-Indies, the Netherlands, the Hebrides.
- Гол мөрөн, нуур, далай, тэнгис, уулс олон тоонд : the Thames, the Atlantic, the Alps
- Орчлонд ганц юмны нэрийн өмнө : the moon - сар, the earth - дэлхий, the sun - нар.
- Өмнө нь дурдсан зүйлээ дахин давтах үед : I bought a postage stamp yesterday. The stamp is very interesting.
- Улс орны нэр нь republic, union, kingdom, states гэсэн үгтэй бол : The United states of America - АНУ
- Ямар нэг бүлэг юмыг ерөнхийд нь нэрлэх үед : the English - англичууд, the old - хөгшчүүл, the wolf - чоно.
- Нэр үгийг тодотгож байгаа дэс тооны өмнө : the first week - эхний долоо хоног, the second floor - гуравдугаар давхар.
- Хавсрал нэрийн давуу зэргийн өмнө : the highest mountain in the world - дэлхийн хамгийн өндөр уул.
- Нэг гэр бүлийг бүхэлд нь нэрлэх үед : the Smiths - Смитийнхэн
- Сонин, найрал дуу, оркестр, поп хамтлагийн нэрийн өмнө : the Daily News, the Bach Choir, the Beatles

Сануулга : all, both, half, double, quite, twice - ын ард нь "the" байна. all the world, double the sum, all the money.

II . Тухайлах ялгац гишүүнийг орхих тохиолдлууд

- Оноосон нэр (мөн poor, old, little, good, saint -тай) бол: poor Peter, little John
- Цол хэргэм ураг төрлийн нэр бол : Admiral Nelson, King Richard, Queen Elizabeth, Uncle Sam, Dr.Miller
гэвч : the Queen of England гэх үед хэрэглэнэ.
Санамж : Англи цол хэргэм биш бол the авна : emperor, czar, archduke, elector : the Emperor William, the Czar Peter I
- Улс болон хотуудын нэр бол: Switzerland, Turkey, London,
гэвч : the London of today - гэх үед хэрэглэгдэнэ.
- Mount- , cape- , lake- , harbour- , bay- тай оноосон нэр байвал : Mount Everest, Cape Trafalgar, Lake Geneva, New York Harbour, Hudson Bay,
гэвч : the Cape of Good Hope гэх үед хэрэглэгддэг.
- Гудамж, талбай, гүүр, барилга оноосон нэртэй бол : Oxford street, Trafalgar square, Windsor castle, London bridge.
- Тоолж үл болох ерөнхий нэрийн өмнө : life, death, love, Earth, Heaven, Hell ; He was weary of life.
гэвч : the life of the whole nation гэх үед ялгац гишүүн авна.

- Нэр үгийн өмнө тооны нэр, төлөөний үг орвол : two boys, his friend, this room, some apples.
- Church, school, college, prison, business, chapel, hospital, market, sea, table, town, work, bed гэх мэт үгс нь ерөнхий утгаар хэрэглэгдвэл : church is over, school begins, he was sent to prison, go to bed.
гэвч : тодорхой утгатай бол ялгац гишүүн хэрэглэгдэнэ : The school is near the church. - Сургууль сүмийн хажууд байдаг.
- Материалын нэр : coal, iron , wood, gold : coal is important for export,
гэвч : the coal of Wales (Уэльсийн нүүрс) гэх мэтээр хэрэглэх нь бас бий.
- Нэр олон тоонд байвал : cats, mice, dogs, birds : swallows are pretty birds.
гэвч : the swallows of this summer - энэ зуны хараацайнууд гэхчилэн ялгац гишүүн хэрэглэх тохиолдлууд байна.
- Улирал, сар, өдөр : summer, March, Sunday : on Monday, in Winter, in April, at Christmas
гэвч : the last Sunday in August. гэх үед хэрэглэнэ.
- Шинжлэх ухааны тусгай салбарын нэрийн өмнө :
My brother studies algebra. - Ах маань алгебр судалдаг.
Photography is my hobby. - Фото зураг бол миний хобби.

Сануулга : "of"- ын тусламжтайгаар холбогдсон буюу түүнтэй адил бүх тохиолдолд ялгац гишүүн авна.

the Cape of good Hope, The England I know

ЭС ТУХАЙЛАХ ЯЛГАЦ ГИШҮҮН (A, AN) (The indefinite article)

1. a : гийгүүлэгчээр эхэлсэн үгийн өмнө : a boy, a lady, a European
 2. an : эгшгээр эхэлсэн үгийн өмнө : an animal, an english book,
мөн үл дуудагдах h-ээр эхэлсэн үгийн өмнө : an hour, an heir, an honour
эхний үе нь өргөлтгүй үгийн h-ийн өмнө : an historian
- Анх яригдаж байгаа ба зөвхөн ганц тоонд байгаа тоологдох нэрийн өмнө : I have a pen. I see a dog.
 - Нэг төрөл зүйлийн юмыг нөгөөгөөс нь ялгахын тулд : a dof is domestic animal.
("нохой" гэсэн ерөнхий утгаар)
 - Мэргэжил, үндэстэн, шашинтан бол : my brother is a painter, he is an englishman, she became a Protestant
гэвч : the title of (doctor), the rank of (general), the dignity of (senator)-ийн дараа эс тухайлах ялгац гишүүнгүй байна.
 - Хэмжээ, жин, цаг, тоолол бол : four shillings a yard, sixpence a pound, twice a year, four times a day
 - Тоо хэмжээ заасан тодорхой үгийн өмнө : a million, a thousand, a dozen, a couple, a little

Санамж : "a" - нь half, such, quite, many (зарим нэг), rather, what - ийн ард байна : half a dozen - 6 ширхэг, such a good story - тийм сайн өгүүллэг.

"a" - нь as, so, too, how, however - ээр холбогдсон хавсрал нэрийн ард байна : as good a swimmer as I am - над шиг сайн сэлдэг хүн ; to heavy a weight - дэндүү хүнд жин ; too difficult a task - маш хэцүү даалгавар

НЭР ҮГ (The noun)

I . Хүйс : Дүрмийн хүйс = Байгалын хүйс

а . Хүн ба эд зүйл

Эр хүйсийн хүн, амьтан эр хүйсийн төлөөний үг авна	he	him	his	he met his friend
Эм хүйсийн хүн, амьтан эм хүйсийн төлөөний үг авна	she	her		she saw her friend
Эд зүйлс болон хийсвэр зүйлс эрс хүйсийн төлөөний үг авна	it	its		the book is in its place

б . Амьтан

Амьтны нэр ерөнхийдөө эрс хүйс авна : The lion licked its paw.

гэвч : Гэрийн тэжээмэл болон үлгэрийн амьтан гол төлөв хүйсээр ялгагдана.

эр хүйсийн (хүчтэй) амьтан = эр хүйс : the dog, his name

эм хүйсийн (сул дорой) амьтан = эм хүйс : the cat, she is dead

Зарим нэр үг "-ess" төгсгөл авч эм хүйс үүсгэдэг. Жишээлбэл : actor - actress, host - hostess, prince - princess, waiter - waitress, lion - lioness, duke - duchess

Санамж : Хөлөг онгоц, улс орон болон хотын нэр гол төлөв эм хүйсийг хэрэглэдэг : the 'Atlantic' lost her crew, England and her dominions

II . Нэр үгийн олон тоо үүсгэх

Singular + s : dog - dogs, friend - friends

Дүрмийн олон тоо үүсгэхдээ ганц тоон дээр "-s" залгадаг. Жишээлбэл : leg - legs, wall - walls, tree - trees, table - tables.

Нэр үгийн төгсгөл нь дараах байдалтай бол :

- s, ss, x, z, ch, sh, tch, бол "-es" залгана. Жиш : ass - asses, box - boxes, church - churches
- гийгүүлэгч + y бол "-ies" залгаж олон тоо үүсгэнэ. Жиш : baby - babies
- fe, f бол "-ves" залгана. Жиш нь : wife - wives, knife - knives, wolf - wolves гэх мэт. Гэвч : chief - chiefs, roof - roofs гэж үүсдэгийг анхаар.
- o - бол "-oes" : hero - heroes, potato - potatoes. Гэвч зарим гадаад үгэнд : photo - photos, piano - pianos, radio - radios гэсэн байдлаар үүсдэг.

Үл өөрчлөгдөх үгс

- зарим шувуу, амьтан : sheep - хонь, deer - буга, swine - гахай, fish - загас, fruit - жимс, grouse - ятуу.
- зарим загас : trout - хулд, salmon - салмон, carp - мөрөг, pike - цурхай гэх мэт. Гэвч herring, -s = май, eel, -s = могой загас гэж үүсдэг үгс ч байдаг.
- яс үндэс, оршин суугчдын нэр : Japanese, Swiss, Vietnamese

ох, child, brother гэсэн үгс бол -(r)en төгсгөл авна : ox - oxen, child - children, brother - brethren

Зарим нэр үг үндсээрээ өөрчлөгдөж олон тоо үүсгэдэг. Жишээлбэл : man - men, woman - women, foot - feet, tooth - teeth, goose - geese, mouse - mice, person - people, louse - lice

Санамж : man - тэй холбогдсон нэр үгс олон тоон дээр : gentleman - gentlemen, Frenchman - Frenchmen гэх мэтээр хувирна.

Гэвч : German, -s; Roman, -s; Norman, -s гэх мэт үгс шууд "-s" залгаснаар олон тоо болно.

Зарим нэг хийсвэр (Abstract) болон хам нэр (Collective) зөвхөн ганц тоонд байна. Жиш : advice - зөвлөлгөө, business - ажил хэрэг, furniture - мебель, knowledge - мэдлэг, merchandise - эд бараа, progress - хөгжил дэвшил гэх мэт.

Санамж : Хоёроос дээш хэсэгтэй зүйлс зөвхөн олон тоонд байдаг : scissors - хайч, tongs - бахь, spectacles - нүдний шил, lungs - уушиг, trousers - өмд, scales - жин хэмжүүр, These spectacles are strong. - Энэ нүдний шил бөх.

Анхаар! : Үйлийн эзэн олон тоонд байвал хувцас болон биеийн хэсгийн нэр олон тоонд байна.

They came in with their hats on their heads - Тэд орж ирэхдээ малгайтайгаа байсан.

III . Тийн ялгал (The case)

Нэрлэх (Normative) = (the, a, an)

Хамаатуулах (Genitive - угтвар үгт хамаатуулах) = of (the, a, an)

Өгөх орших (Dative - угтвар үгт өгөх орших) = to (the, a, an)

Заах (Accusative) = (the, a, an)

Англи хэлэнд угтвар үгт хамаатуулахаас гадна мөн Саксоны хамаатуулах гэж байдаг ба энэ нь нэр үгийн ганц тоонд 's, олон тоонд s' -ийг залгаж хэрэглэдэг. Хэрэглэх тохиолдолууд :

- Хүн амьтанд хамаарагдах зүйлийн тухай ярихдаа : Jack's blue book. they boys' book
- Эд зүйл болон цаг хугацаа, газар орон, тоо хэмжээний тухай ярихдаа : a week's holiday, a month's stay, a mile's walk, at arm's length, a stone's throw
- Ярианы хэллэгт : for Heaven's sake - бүх гэгээн хутагтын төлөө, for God's sake - бурхны тусын тулд, for goodness' sake - сайн сайхны төлөө

Санамж : Хэрэв Саксоны хамаатуулахад house, shop, church, practice гэсэн үгс байвал орхиж бичнэ.

I am at my uncle's (house). - Би эгчийндээ (гэрт) байна. at the doctor's (practice) - эмчийн дадлагад

Өгөх оршихын тийн ялгал нь Заахын тийн ялгалын өмнө байрлавал to - гүй орно.

Өгүүлэгдэхүүн	Өгүүлэхүүн	Өгөх орших	Заах	
We	gave	<u>the beggar</u>	a penny	Бид гуйлгачинд нэг пенни өгсөн
I	sent	<u>you</u>	some books	Би чамд хэдэн ном илгээсэн

Угтвар үгт Өгөх оршихын тийн ялгал : Өгөх оршихын тийн ялгал нь Заахын тийн ялгалын дараа байрлавал to - тэй орно.

Өгүүлэгдэхүүн	Өгүүлэхүүн	Заах	Угтвар үгт Ө.о.тя
We	gave	a penny	<u>to the beggar</u>
I	sent	some books	<u>to you</u> (and not to <u>him</u>)

Өгөх оршихын тийн ялгал нь зарим үйл үг болон хавсрал нэрийн дараа Заахын тийн ялгалын өмнө to - тэй байдаг. Жишээлбэл :

english	mongolian	english	mongolian	english	mongolian
to add	-д нэмэх	to reply to	-д хариулах	cruel to	харгис зэрлэг
to listen to	чагнах, сонсох	to happen to	-д болох тохиолдох	just to	шударга
to declare, explain to	-д мэдэгдэх тайлбарлах	to say to	хэлэх, ярих	polite to	ээлдэг, найрсаг
to mention to	дурдах сануулах	kind to	нөхөрсөг, эелдэг		

Өгөх оршихын тийн ялгал нь зөвхөн Заахын тийн ялгалын утга агуулж байгаа үйл үгэнд холбогддог. Гол хэрэглэдэг үйл үгс нь :

english	mongolian	english	mongolian	english	mongolian	english	mongolian
to give	өгөх	to bring	авчрах	to forgive	уучлах	to tell	хэлэх
to lend	зээлүүлэх	to take	-д аваачих	to cost	инэтэй байх	to write	бичих
to offer	санал тавих	to send	-д илгээх	to owe	ертэй байх	to sell	худалдах
to promise	амлах	to fetch	авчрах	to pay	телех	to show	зүйлэх

Санамж : Заахын тийн ялгал "it" - нь биеийн төлөөний үгийн Өгөх оршихын тийн ялгалын өмнө байрлана :
give it me - үүнийг надад өгөөч ; bring it us - үүнийг бидэнд авч ирээч

ХАВСРАЛ НЭР (The adjective)

Тэмдэг нэр буюу хавсрал нэр нь байнга өөрчлөгддөггүй. The great poets of England - Английн их найрагчид. гэх мэт

I. Хавсрал нэрийн харьцуулалтын зэрэг (Degrees of Comparison of the Adjective)

	Зөвшөөх (positive)		Харьцуулсан(comparative)		Давуу (superlative)	
			- er		- est	
Богино үет	long	урт	longer	арай урт	the longest	хамгийн урт
	large	том	larger	арай том	the largest	хамгийн том

Олон үет			more		most	
	beautiful	гоё	more beautiful	илүү гоё	the most beautiful	хамгийн гоё
Дүрэм бус	good	сайн	better	илүү сайн	the best	хамгийн сайн
	bad	муу	worse	бүр муу	the worst	хамгийн муу

Жич : **Давуу зэрэгт** хавсралт нэрийн өмнө тухайлах ялгац гишүүн "the"-г хэрэглэнэ.

- **Богино үет хавсрал нэрэнд** : a) нэг үет хавсрал нэр b) хоёрдугаар үе дээрээ өргөлттэй хавсрал нэр : (polite - politer - the politest , severe - severer - the severest) болон гийгүүлэгчийн дараа -y, -le, -er, -ow, - some -ээр төгссөн хоёр үет хавсрал : happy - happier - the happiest, clever - cleverer - the - cleverest .
- **Олон үет хавсрал нэрэнд** : a) эхний үедээ өргөлттэй хоёр үет хавсрал нэр : cautious - more cautious - the most cautious, useful - more useful - the most useful. b) олон үет хавсрал нэр болон хавсрал нэрийн үүргээрх нөхцөл үйл үгүүд : interesting - more interesting - the most interesting, delighted - more delighted - the most delighted.

Хавсрал нэрээс харьцуулалтын зэрэг үүсгэх бичлэгийн дүрэм :

- "e" - ээр төгссөн бол гэж -er, -est залгана. Жиш : fine - finer - finest, polite - politer - politest
- үгийн эцэст гийгүүлэгчийн дараа "y" байгаа бол "y" - нь "- i -" болно. Жиш : dry - drier - driest, happy - happier - happiest.
- үгийн эцэст дан гийгүүлэгч байх, эцсийн гийгүүлэгчийн өмнө богино эгшиг байх, үгийн эцсийн үе өргөлттэй байх тохиолдолд эцсийн гийгүүлэгчийг давхар бичдэг. Жиш : big - bigger - biggest, hot - hotter - hottest, fit - fitter - fittest.

Дараах хавсрал нэрүүд хавсрал нэрийн зэргийг хоёр хэлбэрээр үүсгэхдээ өөр өөр утга агуулдаг.

<u>Зөвшөөх</u>	<u>Харьцуулсан зэрэг</u>	<u>Давуу зэрэг</u>	<u>Илэрхийлэх утга</u>	<u>Хэрэглэх жишээ</u>
late	later	latest	цаг хугацаа	I'll see you later - Би чамтай дараа уулзана. the latest paper - сүүлчийн баримт
	latter	last	дэс дараа	the latter sentence - дараачийн өгүүлбэр, (the) last time - сүүлчийн удаа
far	farther	farthest	орон зайн	the farthest way - хамгийн хол зам
	further	furthest	дүрслэл	without further delay - цаашид саатахгүйгээр
old	older	oldest	насны ялгаа	he is older than I - тэр надаас ахмад, the oldest tree - хамгийн хөгшин мод
	elder	eldest	зөвхөн хамаатан садны насны ялгаанд тодотголын үүргээр	my elder brother - миний ах, his eldest son - түүний том хүү

near	nearer	nearest	орон зайн	the nearest way to the station - буудал хүрэх хамгийн дөт зам
	next		цаг хугацаа болон дэс дараа	next month - дараагийн сар. the next stop - дараагийн буудал
little	smaller	smallest	жижиг гэсэн хэмжээ	the smallest room - хамгийн жижиг өрөө
	less	least	бага гэсэн хэмжээг	he drinks less wine than milk - тэр сүүг бодвол дарс бага уудаг

II . Харьцуулсан хам бүтэц

- Ижил байдал : as - as : my sister is as big as I am - миний эгч над шиг том.
- Ижил биш байдал : not so - as (эсвэл not as - as) : he is not so (not as) tall as his brother - тэр ах шигээ тийм өндөр биш
- эсвэл харьцуулсан зэрэг (comparative) + than : he is bigger than his brother - тэр ахаасаа илүү том юм.
- the - the : the further they went the worse the road was - цааш явах тутам зам муудсан.
- the less - the less : the less you work, the less you will earn - чи бага ажиллах тусам бага мөнгө олно.

Санамж :

the former - өмнөх нь, эхнийх нь

the same the - . . . шиг адилхан

the latter - . . . сүүлчийнх нь

other than - . . . -с өөр, . . . -с ондоо

III . Хавсрал нэр нэрших нь (Substantivization of adjectives)

Хэсэг бүлэг хүмүүсийг нас, үндэс угсаа, бие бялдар, хөрөнгө чинээ гэх мэт онцлог шинж чанараар нь нэрлэхдээ хавсрал нэрийг **ерөнхий** буюу **хийсвэр нэрийн үүргээр the** - ийн **хамт** хэрэглэдэг ба **олон тоонд хувирдаггүй**.

the good сайчууд Хавсрал нэрээс үүссэн ерөнхий нэр үгээс онцолж тодорхой бүлэг
the blind хараагүйчүүд хүн, хэн нэг хүнийг нэрлэхдээ **man / woman, boy / girl, gentleman / lady, person / people** гэх мэт төлөөний үг хэрэглэдэг. Жиш : **the blind women, the poor person, poor people . . .** гэх мэт
the poor ядуучууд

"-sh", "-ch" - ээр **төгссөн яс үндэс** заасан үгс нь **олон тооны хэлбэрт хувидаггүй** ба эдгээрээс тодорхой нэг хүнийг яс үндсээр нь **онцлохдоо man / woman, gentleman / lady** - ийн тусламжтайгаар нэрлэдэг.

Жиш : **the English - an Englishman, the French - a French lady, the Scotch - two Scotchmen, the Dutch some Dutchmen**

Зарим яс үндэс заасан үгс нь олон тооны хэлбэрт байдаг. Жиш : **(the) Americans, (the) Germans, (the) Russians**

IV . Хавсрал нэрийг хэрэглэх хэлбэр

1. Хавсрал нэр нь **нэр үгийн өмнө** орж **тодотголын үүрэг** (attributive use) гүйцэтгэнэ. Жиш : **This is an interesting book.** - Энэ бол **сонирхолтой** ном. **They live in the old house.** - Тэд **хуучин** байшинд амьдардаг.
2. Хавсрал нэр нь **үйл үгийн ард** орж **өгүүлэхүүний хэрэглээ** (predicative use) болдогв Жиш : **This book is interesting.** - Энэ ном **сонирхолтой**. **Their house is old.** - Тэдний байшин **хуучин**.

ҮЙЛ ХАВСРАЛ (Adverb)

Дайвар үг буюу хавсрал нь үйлийн шинж чанар, байр, байдал, цаг хугацаа, зэрэг, давтамжийг заадаг.

I. Үйл хавсрал үүсгэх хэлбэр

Adjective + ly = Adverb , Хавсрал нэрэнд ихэвчлэн **"-ly"** залгаж үүсмэл **үйл хавсрал** үүсгэдэг ба дараах дүрмийг баримтлана.

1. **Хоёр** ба **түүнээс дээш үетэй** хавсрал нэрийн сүүлийн **гийгүүлэгч + "-y"** бол **"-y"**-ийг **"-i"** -ээр солино. Жиш : **happy - happily, easy - easily.**
2. **Нэг үетэй** хавсрал нэрийн **"-y"** -ийг хэвээр **хадгалж** болно. **dryly** ба **drily**, **жич : gay - gaily** байх тохиолдол бий.
3. Дараах үгүүдийн **-e** төгсгөлийг **гээнэ**. **true - truly, whole - wholly, due - duly, noble - nobly**
4. **full - fully**
5. хавсрал нэр нь **"-ic"** төгсгөлтэй бол **"-ally"** -г залгаж үүсгэнэ. Жиш : **fantastic - fantastically, diplomatic - diplomatically**

Анхаар! Хавсрал нэр нь **"-ly"** төгсгөлтэй бол **in a . . . manner (way)** бүлэг үгс ашиглан сольж болно. Жиш : **in a friendly manner; in a lovely way**

Хавсрал нэр болон үйл хавсралын **адил хэлбэрүүд** байдаг. Жишээ нь **цаг хугацааг заахад "-ly"** : **early, daily, weekly, monthly, yearly . . .** гэх мэт

Гэвч ижил хэлбэртэй боловч **өөр өөр утга** илэрхийлдэг. Жишээ нь

	pretty	only	still	very
Хавсрал нэр (adjective)	хөөрхөн	цорын ганц	нам гүм	жинхэнэ, үнэн, яг
Үйл хавсрал (adverb)	нэлээд	зөвхөн, ердөө	бас ч, арай ч	тун, маш, их

Зарим **"-ly"** дагавар авч үүссэн үйл хавсрал **үндсэн утгаа гээдэг** тохиолдол бий. Жиш : **hardly** - чүү чамай, арай ядан ; **nearly** - бараг, шахуу

Санамж : **" маш их" = very** - нь хавсрал нэр болон үйл хавсралын өмнө хэрэглэгддэг : **very good, very badly,** (very) **much** үйл үгэнд : **I thank you very much.**

Санамж : **Хавсрал нэр (Adjective)** нь **үйл хавсралын (adverb)** оронд дараах байдлаар илэрхийлэгддэг : **to work hard** - их ажиллах, **to walk slow** - явган удаан явах, **to talk loud (low)** - чанга ярилцах, **to spell right (wrong)** - зөв (буруу) дуудах, **to feel happy** - аз жаргалыг мэдрэх, **to stop short** - түр зогсох

II. Үйл хавсралын харьцуулалтын зэрэг (Degrees of Comparison of the adverb)

1. Олон үет харьцуулалтын зэрэг : ("-ly" -ээр үүссэн бүх үйл хавсрал "more, most" - ийг авч)
brightly - more brightly - most brightly ; slowly - more slowly - most slowly
2. Богино үет харьцуулалтын зэрэг : ("-ly" залгаж үүсээгүй буюу үндсэн үйл хавсрал "-er, est" авч)
soon - sooner - soonest ; often - oftener - oftenest ; early - earlier - earliest
3. Дүрэм бус харьцуулалтын зэрэг :
well - better - best ; badly - worse - worst ; little - less - least ; much - more - most
late - latter - last ; far - farther (further) - farthest (furthest) ; near - nearer - nearest (next)

III. Үйл хавсралыг хэрэглэх хэлбэр

Үндсэн дүрэм : Үйл хавсрал нь хэзээ ч өгүүлэхүүн болон тусгагдахууны хооронд байрладаггүй.

Өгүүлбэрт байрлах дүрэм :

1. **Өргөлттэй үйл хавсрал** (байрлал, тодорхой цаг заасан үйл хавсрал болон байдал заасан өргөлттэй үйл хавсрал) нь **өгүүлбэрийн эхэнд буюу эцэст** байрлана. (өргөлт анхаар!) Жишээ нь :
Байрлал заасан : in 1999 we went to London
Тодорхой цаг заасан : I met him yesterday.
Байдал заасан : We thanked him heartily
2. **Өргөлтгүй үйл хавсрал** (тодорхой бус цаг заасан үйл хавсрал болон байдал заасан өргөлтгүй үйл хавсрал) нь **жирийн одоо цаг бол үйл үгийн өмнө, нийлмэл цаг бол эхний туслах үйл үгийн ард** байрлана. Жишээ нь :
Тодорхой бус цаг : She always heard the child cry. - Тэр хүүхэд уйлахыг үргэлж сонсдог байсан.
I have often been in America - Би дандаа Америкт байсан
Байдал заасан : I did not quite understand you. - Би таныг ердөө ойлгонгүй.
3. Өгүүлбэрт **олон үйл хавсрал** байх бол байрлал нь : **Байдал + байр + цаг** гэсэн дараалалтай байна. Жишээ нь : We arrived safely in London yesterday.

ТООНЫ НЭР (The Numeral)

Үндсэн тооны нэр (Cardinal numerals)

1 - one, 2 - two, 3 - three, 4 - four, 5 - five, 6 - six, 7 - seven, 8 - eight, 9 - nine, 10 - ten, 11 - eleven, 12 - twelve, 13 - thirteen, 14 - fourteen, 15 - fifteen, 16 - sixteen, 17 - seventeen, 18 - eighteen, 19 - nineteen, 20 - twenty, 21 - twenty one, 22 - twenty two, 30 - thirty, 40 - forty, 50 - fifty, 60 - sixty, 70 - seventy, 80 - eighty, 90 - ninety, 100 - a (one) hundred, 101 - a (one) hundred and one, 200 - two hundred, 1000 - a (one) thousand, 2000 - two thousand, 100 000 - a (one) hundred thousand, 1 000 000 - a (one) million, 2 000 000 - two million(s)

Дэс тоо ба бутархай тоо (Ordinal numerals and Fractional numerals)

Ordinal numerals = Cardinal numerals + th : the hundredth . Дүрэм бус : first, second, third (1st, 2nd, 3rd)

Бичих үед анхаар : five - fifth, eight - eighth, nine - ninth, twelve - twelfth, twenty - twentieth

ГЭХ МЭТ.

Цаг тоолол : He was born on July 14th буюу on the 23rd of July ; Хаад ноёдын нэр : Elizabeth II - Elizabeth the second (уншихдаа)

Дэс тооны өмнө "the" тухайлах ялгац гишүүн авдаг. the first, the second, the eleventh, 101 - the hundred and first

Энгийн бутархай (Common Fractions): 1/2 а (one) half, 1/3 one third, 2/5 two fifths, 2.3/7 two and three sevenths

Аравтын бутархай (Decimal Fractions): 0.3 nought (zero) point three, 2.35 two point three five (thirty five)

Тоон үйл хавсрал

Дэс дараа : эхлээд - дараа нь = first - then :

First he lived at home, then he went to England. - Эхлээд тэр гэртээ амьдарч байсан дараа нь Англи явсан.

Зөрчил : эхэндээ - сүүлдээ = at first - at last, at length :

At first I believed him, but at last I became distrustful. - Эхний удаа би түүнд итгэсэн, харин эцэст нь итгэлгүй болсон.

Бүртгэх : нэгдүгээрт = firstly буюу in the first place ; гуравдугаарт = thirdly буюу in the third place . . . ; тавын тооноос эхлээд зөвхөн in the fifth place гэх мэт. Жишээ нь : зургадугаарт = in the sixth place

<u>Давтамж</u> :	нэг удаа	=once	хэдэн удаа?	=how many times?	гурван удаа	three times (thrice)
	хоёр удаа	=twice	заримдаа, хааяа	=sometimes	дахин	once more

<u>Хувилалт:</u>	нэг дахин	=single	гурав дахин	=treble, threefold	100 дахин	=a (one) hundredfold
	хоёр дахин	=double	дөрөв дахин	=fourfold	олон дахин	=manifold гэх мэт

БИЕЙН ТӨЛӨӨНИЙ НЭР, ХАМААТУУЛАХ ТӨЛӨӨНИЙ НЭР, ЭГЭХ БА ХҮЧ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨЛӨӨНИЙ НЭР (Personal, Possessive, Reflexive and Emphatic Pronouns)

Биеийн төлөөний нэр		Хамаатуулах төлөөний нэр		Эгэх ба хүч нэмэгдүүлсэн т.н <u>-self</u> - дээр өргөлт авна.
Нэрлэх = өгүүлэгдэхүүн Nominative = Subject	Заах = Тусгагдахуун Accusative = Objective	I хэлбэр	II хэлбэр	
I -би	me -намайг, надад	my - миний	mine - минийх	myself - (би)

				өөрийгөө, өөрөө
you - чи	you - чамайг, чамд, таньд, таныг	your - чиний, таны	yours - чинийх, таных	yourself - (чи, та) өөрийгөө, өөрөө
he - тэр (эрэгтэй)	him - түүнийг, түүнд	his - түүний	his - түүнийх	himself - өөрийгөө, өөрөө (эрэгтэй)
she - тэр (эмэгтэй)	her - түүнийг, түүнд	her - түүний	hers - түүнийх	herself - өөрийгөө, өөрөө (эмэгтэй)
it - энэ, тэр юм	it - түүнийг, түүнд, үүнийг, үүнд	its - үүний (эд зүйл)	its - үүнийх	itself - өөрийгөө, өөрөө (энэ, тэр юм)
we - бид, бид нар	us - биднийг, бидэнд, бид нарт	our - манай, бидний	ours - манайх, биднийх	ourselves - өөрсдийгөө, өөрсдөө (бид)
you - та нар	you - та нарыг, та нарт	your - танай, та нарын	yours - танайх, та нарынх	yourselves - (та нар) өөрсдийгөө, өөрсдөө
they - тэд, тэд нар	them - тэднийг, тэд нарыг, тэдэнд	their - тэдний, тэд нарын	theirs - тэднийх, тэд нарынх	themselves - (тэд) өөрсдийгөө, өөрсдөө
one	one	one's	one's (own)	oneself

Сануулга : **Биеийн төлөөний нэр нь**

Өгөх оршихын тийн ялгалд заахын тийн ялгалын **өмнө** бол **to -гүй** : **give me the book**

Өгөх оршихын тийн ялгалд заахын тийн ялгалын **дараа** бол **to -тэй** : **give the book to me**

Төлөөний нэрийг өгүүлбэрт хэрэглэх нь :

<u>Төлөөний нэрс</u>	<u>Гүйцэтгэх үүрэг</u>		<u>Жишээ</u>
Биеийн	Нэрлэхийн т.я-д	өгүүлэгдэхүүн	I shall speak to him. - Би түүнтэй ярина.
		өгүүлхүүн	That was he. - Тэр бол тэр байв.
	Заахын т.я-д	тусгагдахууны үүргээр	I shall speak to him. - Би түүнтэй ярина.
Хамаатуулах	I хэлбэр нь	тодотголын үүргээр	Her paper was interesting. - Түүний өгүүлэл сонирхолтой байсан
	II хэлбэр нь	өгүүлэгдэхүүн	My ruler is long yours is longer. - Миний шугам урт, чинийх бүр урт.
		өгүүлэхүүн	This car is his. - Энэ машин түүнийх .
		тусгагдахуун	We haven't seen your paper, we have seen only theirs. - Бид чиний зохион бичлэгийг үзээгүй, зөвхөн тэд нарынхыг үзсэн

<u>Эгэх</u>	<u>тусгагдахууны үүргээр</u>	I wash <u>myself</u> . - Би <u>өөрийгөө</u> угаадаг.
<u>Хүч нэмэгдүүлэх</u>	<u>нэр үг (төлөөний нэр)-ийн утгыг хүч нэмэгдүүлэх үүргээр</u>	He <u>himself</u> saw it. - Тэр <u>өөрөө</u> үүнийг үзсэн. He saw it <u>himself</u> . - Тэр үүнийг <u>өөрөө</u> үзсэн.

ҮЙЛДЭХ ТӨЛӨӨНИЙ НЭР (Reciprocal pronouns)

each other - хэн хэнийгээ, **one another** - нэг нь нөгөөгөө, Жишээ нь :

They greeted each other. - Тэд бие биентэйгээ мэндлэв.

We know each other very well. - Бид бие биенээ тун сайн мэднэ.

The children look at each other in the mirror. - Хүүхдүүд толинд бие биенийгээ хардаг.

ЗААХ ТӨЛӨӨНИЙ НЭР (Demonstrative pronouns)

	<u>Ойр</u>	<u>Хол</u>
Ганц тоо	this - энэ	that - тэр
Олон тоо	these - эдгээр	those - тэдгээр

1. **Өгүүлэгдэхүүний үүргээр** : This was pleasant. - Энэ нь аятайхан байсан.
2. **Өгүүлэхүүний хэсгийн үүргээр** : It was that. - Энэ бол тэр байсан.
3. **Тусгагдахууны үүргээр** : He likes this. - Түүнд энэ таалагддаг.

АСУУХ ТӨЛӨӨНИЙ НЭР (Interrogative Pronouns)

Тийн ялгал	1. Нэр үг			2. Хавсрал нэр
	Хүн	Эд зүйл	Хүн ба эд зүйл (сонголт, ангилалт)	Хүн ба эд зүйл
Нэрлэх	who? = хэн? Who can swim?	what? = юу? What is this?	which? = аль, ямар, хэн, юу? Which of you is ill?	what?, which?
Харъяалах	whose = хэний? of whom? = хэний тухай? 1. Whose book is this? 2. Of whom did you speak?	of what? = юуны тухай? Of what did you speak?	of which? = хэнийх, юуных? There were two accidents. Of which did you hear?	what (which) boy? what (which) table?
Өгөх орших	to whom? = хэнд? To whom did you give?	to what? = юунд? To what does this refer?	to which? There are two teams, to which do you belong?	
Заах	whom? = хэнийг? Whom did you see?	what? = юуг? What do you see?	which? Which do you like?	

	call?		better, tea or coffee?	
--	-------	--	------------------------	--

Санамж : Асуух төлөөний нэрэнд **угтвар үгс (Prepositions)** орохдоо **гол төлөв үйл үгийн ард** байрлана :

Whom are you speaking of? - Чи хэний тухай ярьж байна.

What is he laughing at? - Тэр юуг шоолж байна?

What are you talking about? - Та юуны тухай ярьж байна.

ХОЛБОХ БА НЭГТГЭХ ТӨЛӨӨНИЙ НЭР (Relative and conjunctive pronouns)

Тийн ялгал	Хүн дээр	Эд зүйлд	Хүн ба эд зүйл
Нэрлэх	who	which	that
Харъяалах	whose, of whom	of which (whose)	(that - of)
Өгөх орших	to whom	to which	(that - of)
Заах	whom	which	that

Нэрлэх	<u>who</u>	my friend <u>who</u> made a trip to London	- Лондон руу аялсан миний найз
Харъяалах	<u>whose</u>	the girl <u>whose</u> father I know	- аавыг нь мэдэх охин
		the house <u>whose</u> walls are grey	- саарал ханатай байшин
	<u>of whom</u>	the boy <u>of whom</u> we spoke	- бидний ярьж байгаа хүү
Өгөх орших	<u>to whom</u>	the pupil <u>to whom</u> he gave the book	- түүний номоо өгсөн сурагч
Заах	<u>whom</u>	the man <u>whom</u> I asked	- миний юм асуусан тэр эмэгтэй
Нэрлэх	<u>which</u>	the train <u>which (that)</u> arrived	- ирсэн галт тэрэг
Харъяалах	<u>of which</u>	the house, the windows <u>of which</u> . . .	(ард нь үргэлж түүнтэй холбоотой үг орно)
Өгөх орших	<u>to which</u>	the story <u>to which</u> we listened	- бидний сонссон түүх
Заах	<u>which</u>	the things <u>which (that)</u> we need	- бидэнд хэрэгтэй зүйлс

Санамж : Холбох ба нэгтгэх төлөөний нэртэй хамт **угтвар үгс нь (Preposition)** орохдоо **үйл үгийн ард** байдаг.

The man whom I was waiting for. - Миний хүлээж байгаа эрэгтэй.

The house, that I lived in. - Миний суудаг байшин.

that - зөвхөн **тодотгол гишүүн өгүүлбэрт** байдаг дараах тохиолдлуудад хэрэглэнэ.

1. **who, which**-ын оронд :
Who was the man that you were talking of? - Чиний ярьж байсан эрэгтэй хэн бэ?
This is the bird (that) he caught. - Энэ бол түүний барьсан шувуу.
2. Тодорхойгүй төлөөний нэр (Indefinite pronouns) болон тооны ухагдахууны дараа : **all, everything, something, anything, much, little, nothing, the same** :
That is everything (that) I know. - Миний мэдэх бүх юм энэ.
3. Ямар нэг юм онцлоход **it is . . . , it was . . .** -ын дараа :
It was the storm that destroyd the house. - Байшин нураасан юм шуурга байсан.
4. Хэрэв төлөөний нэр нь хүн ба эд зүйлээс хамаарч байвал :
They talked about the natives and plants (that) they had found interesting. - Тэдэнд сонирхолтой санагдсан амьтан ургамалын талаар тэд ярилцсан.

Санамж : **that** -ийн өмнө хэзээ ч **угтвар үг** байрладаггүй ба угтвар үг нь **үйл үгийн ард** байрлана.

The train that I waited for arrived. - Миний хүлээж байсан галт тэрэг ирлээ.

Анхаар : Хэрэв **тодотгол гишүүн өгүүлбэрт** тусгагдахуун юм уу үйл хавсрал байвал **холбох ба нэгтгэх төлөөний нэрийг гээж болдог**.

This is the boy (whom) like best. - Надад хамгийн их таалагддаг хүү бол энэ.

The house (that) we live in. - Бидний амьдардаг байшин.

ТОДОРХОЙГҮЙ ТӨЛӨӨНИЙ НЭР (Indefinite pronouns)

some = зарим, хэд, жаахан, ямар нэгэн бага зэрэг (тооны нэрийн өмнө)

1. **хэмжээ хязгаар илэрхийлэхэд хэрэглэгддэг**: We had **some** books. - Бидэнд хэдэн ном байлаа.
2. **Зөвшөөрсөн хүүрнэх өгүүлбэрт хэрэглэгддэг**: In the evening we had **some** tea. - Орой бид цай уусан.

any = ямар нэгэн, дүрийн, альч

1. **үнэхээр биш, хэдийд ч байхыг** бага зэрэг илэрхийлдэг: You may come at **any** time. - Та хэзээ ч ирж болно.
2. а) **асуух** өгүүлбэрт: Do you see **any** mistakes? - Та ямар нэгэн алдаа хардаг уу?
б) **үгүйсгэсэн** өгүүлбэрт: No, I do not see **any** mistakes. - Үгүй, би ямарч алдаа хардаггүй.
с) **болзох** өгүүлбэрт: If you see **any** mistakes ... - Хэрэв та ямар нэгэн алдаа харвал ...
3. **зөвшөөрөх өгүүлбэрт "ямар нэгэн"** гэсэн утга гаргахад: Give me **any** book. - Надад ямар нэгэн ном өгөөч.

Мөн **some** болон **any**-гээр нийлмэл үг бүтээдэг.

someone, somebody - хэн нэгэн, зарим хүн; **something** - нэг юм, ямар нэг юм;

somewhere - хаа нэг газар, ямар нэг газар, хаан ч; **anyone, anybody** - ямар нэг хүн, хэн ч;

anything - ямар нэг, аливаа юм, юм; **anywhere** - хаа нэгтэй, хаа нэг газар, хаана ч, хаашаа ч

each = нэг бүр, тус бүр, тутам, бүр (хүн, юм нэг бүрийг тусад нь авч үзэхэд хэрэглэдэг)

- хавсрал нэрийн үүргээр: **Each** player did his best - Тоглогч бүр чадах бүхнээ хийсэн

- нэр үгийн үүргээр: **Each of them did his best** - Тэд бүгд чадах бүхнээ хийсэн

every = бүр (хүн, юмсын тухай ерөнхий ойлголт илэрхийлэхэд)

- зөвхөн хавсрал нэрийн үүргээр : **Every house has a roof** - Байшин бүр дээвэртэй.
- нийлмэл үг бүтээхэд : **everyone, everybody** - хүн бүр, бүгд, хүн болгон; **everything** - юм бүгд, бүх юм
- хэллэг : **every day** - өдөр тутмын; **every fortnight** - 14 хоногийн; **every other day** - өнжөөд

all = бүх, бүгд (ерөнхий юмнаас тодорхой хэсэг бүлгийг авч үзэхэд хэрэглэгднэ)

- хавсрал нэрийн үүргээр: **all men** - бүх эрчүүд
- нэр үгийн үүргээр: **all of them** - тэд бүгдээрээ
- үйл хавсралын үүргээр: **he was all dirty** - тэр заваан байсан
- хэллэг : **all the better** - тэгвэл бүр сайн; **not at all** - зүгээр, зүгээр; **all at once** - нэг мөсөн; **after all** - эцэст нь, сүүлд нь; **first of all** - эхлээд, юуны өмнө; **once for all** - бүр мөсөн; **all the day** - бүхэл өдөр, бүхэл өдөржингөө;

whole = бүх, бүгд (**all** - оос илүү ерөнхий байдал заадаг): **the whole town, the whole of Asia**

- хэллэг : **the whole day** - бүхэл өдөр, бүхэл өдөржингөө;

either = аль нэг нь, аль нь ч; **neither** = аль нь ч биш, ямарч, хэн ч биш, юу ч биш

- хавсрал нэрийн үүргээр: **on either side of river** - голын аль нэг эрэг дээр; **neither way is right** - аль ч зам нь буруу
- нэр үгийн үүргээр: **either one or the other one must leave** - аль нэг нь явах ёстой; **neither of us could help him** - бидний хэн нь ч түүнд тусалж чадахгүй байсан

Санамж: **either ... or** - ... юм уу эсвэл ...; **neither ... nor** - ... ч үгүй ... ч үгүй

nor - either	- мөн	I cannot swim, nor my borther either - би сэлж чаддаггүй, ах маань ч мөн адил
not - either	үгүй	I cannot swim, he cannot swim either - би сэлж чаддаггүй, тэр мөн сэлж чаддаггүй

other = нөгөө, өөр, бусад

- хавсрал нэрийн үүргээр: **the other girl** - нөгөө охин
- нэр үгийн үүргээр: **the others stayd at home** - бусад нь гэртээ үлдсэн
- хэллэг: **the other day** - саяхан, саявтар; **the other morning** - саяхны өглөө; **every other day** - өнжөөд; **one after another** - ар араасаа; **some day or other** - ямар нэг өдөр; **some time or other** - хэзээ нэгэн цагт, санамсаргүй; **on the other hand** - нөгөөтэйгүүр; **another (cup of coffee)** - өөр бас нэг (аяга кофе)

Ганц тоо	Олон тоо	Санамж
----------	----------	--------

much = их it takes too much time	many = олон many families live there	many a = зарим (нэг) a little = бага зэрэг, жаахан a few = хэдэн, цөөн, хэдхэн
little = бага I have little hope	few = цөөн I saw only few boys	

хэлллэг

a great deal of = үнэхээр их; a good many = маш олон, тун их; very much = маш их; in few words = цөөн үгээр; very many, great many = маш олон

ЖИРИЙН ҮЙЛ ҮГ (Ordinary verbs)

Дүрмийн үйл үгсийг гол цагуудад өгүүлбэрийн төрлүүдээр to open (нээх, онгойлгох) үйл үгээр төлөөлүүлэн үзүүлэв.

Өгүүлбэрийн хэлбэрүүд Гол цагууд	Батлах өгүүлбэр (Affirmate)	Үгүйсгэх өгүүлбэр (Negative)	Асуух өгүүлбэр (Interrogative)	Асууж үгүйсгэх өгүүлбэр (Interrogative-negative)
Жирийн одоо цаг (The present indefinite tense)	I open he opens	I do not open he does not open	do I open? does he open?	do I not open? does he not open?
Жирийн өнгөрсөн цаг (The past indefinite tense)	I opened	I did not open	did I open?	did I not open?
Одоо төгссөн цаг (The present perfect tense)	I have opened	I have not opened	have I opened?	have I not opened?
Өнгөрөн төгссөн цаг (The past perfect tense)	I had opened	I had not opened	had I opened?	had I not opened?
Жирийн ирээдүй цаг (The future indefinite tense)	I shall open you will open	I should not open you will not open	shall I open? shall (will) you open?	shall I not open? shall (will) you not open?
Өнгөрсөн цагийн өнгөнөөс эс тухайлах ирээдүй цаг (The future indefinite in the past)	I should open you would open	I should not open you would not open	should I open? should (would) you open?	should I not open? should (would) you not open?

Жич:

- Хэзээ ч ирээдүй цаг болон өнгөрсний ирээдүй цаг нь when, if, while, as soon as - аар холбогдсон хавсарсан нийлмэл өгүүлбэрт цуг ордоггүй.
Жнь:

I shall go out when I am ready - би бэлэн болохоороо гадагшаа гарна.
he would do it if he could - тэр чаддаг байсан бол үүнийг хийх байсан.

ТУСЛАХ ҮЙЛ ҮГС (Auxiliary verbs)

to have = -тай, тэй

- Үйл үгийн **нийлмэл цаг** бүтээхэд хэрэглэгддэг : **he has come** - тэр ирсэн
- **to have + тусагдахуун + өнгөрсөн цагт нөхцөлт үйл үг** бол = - уулна, үүлнэ: **I have my hair cut** - Би үсээ тайруулсан.
- **to have + заахын т/я + эс тухайлах төлөв (infinitive)** бол = -уулах, үүлэх, - лгах, хийлгэх : **the teacher will the boys learn by heart** - багш хөвгүүдийг цээжлүүлэх болно.
- **to have + to -тэй эс тухайлах төлөв (infinitive with to)** бол = ёстой : **he has much to do** - тэр их зүйл хийх ёстой.
- хэрэв **to have** - нь **жирийн үйл үгийн үүргээр** (гол төлөв got гэсэн үгээр хүч нэмэгдүүлдэг) бол : have you (got) a new house? **Асуух** болон **үгүйсгэх хэлбэрт to do** - ийн тусламжтайгаар өөрчлөн бичиж болдог. **Do you have a new house?** - Чи ямар нэгэн шинэ байшинтай юу?

to be = байх

- **Идэвхгүй хэв (passive)** үүсгэхэд хэрэглэгддэг: **the story was told by father** - аавын ярьж өгсөн түүх
- **Үргэлжлэх цагийн хэв (progressive form)** үүсгэхэд хэрэглэгддэг: **it is raining** - бороо орж байна.
- **to be + to - тэй эс тухайлах төлөв (infinitive with to)** бол = тэгэх ёстой (3 дагч этгээдийн хүсэлт буюу хувь тавилангийн эрхээр хийгдэж байгаа илэрхийлнэ) : **he was to die in Africa** - тэр Африкд үхэх ёстой байсан.
- **to be + идэвхгүй хэвийн эс тухайлах төлөв** = -ах ёстой: **the lesson is to be finished** - хичээлийг дуусгах ёстой.
- **to be** - нь **жирийн үйл үгийн үүргээр** бол: "To be or not to be" that is the question - "Орших эс орших" нь асуудал.

to do = хийх, үйлдэх

- Хэрэв **өгүүлэхүүн нь жирийн үйл үг** бол **асуух өгүүлбэр** зохиоход хэрэглэнэ: **do you like it?** - танд энэ таалагдаж байна уу?
Асуух өгүүлбэрийг дараах тохиолдлуудад **to do**-гийн тусламжтайгаар өөрчлөхгүй:
 1. Хэрэв өгүүлэхүүн нь **туслах үйл үгтэй** хамт бол: **will he come?** - тэр ирэх үү?
 2. Хэрэв **өгүүлэгдэхүүнээр эхэлсэн асуух өгүүлбэр** бол: **who knows that?** - Хэн үүнийг мэдэх вэ?
гэвч асуух өгүүлбэр нь үгүйсгэсэн хэлбэрт байвал **to do** -ийг хэрэглэнэ: **who does not know that?** - Хэн үүнийг мэдэхгүй вэ?
- Жирийн үйл үгийг **үгүйсгэх хэлбэрт** оруулахад хэрэглэнэ: **we do not forget it** - бид үүнийг мартажгүй
Үгүйсгэх хэлбэрийг дараах тохиолдлуудад **to do** - гийн тусламжтайгаар өөрчлөхгүй:
 1. ямар нэгэн **туслах үйл үгтэй** бол : **he cannot swim** - тэр сэлж чаддаггүй.

2. **not** (**never, nothing etc.**) - ийн тусламжтайгаар үүссэн бусад үгүйсгэх хэлбэрт : **you never can tell** - та хэзээ ч хэлж чадахгүй. **we sow nothing** - бид юу ч хараагүй.
3. Хэрэв **not** нь үйл үгийг биш харин **асуух өгүүлбэрийг нийтэд нь үгүйсгэж байвал**: **is she ill? - no I suppose not.** Тэр өвчтэй юм уу? Үгүй би тэгж бодохгүй байна.

Санамж: Захиран тушаах төлөвийн үгүйсгэх хэлбэр ямагт **to do** -гээр үүсдэг ба мөн туслах үйл үгтэй бол **to have** болон **to be** -гээр үүсдэг: **do not have a look at it? - don't be sorry!** - Үүнийг хараагүй юу? Бүү харамс!

- урьдах (өмнө нь гарсан) жирийн үйл үгээ **to do** -гээр **орлуулахдаа** дараах тохиолдлуудад хэрэглэгдэнэ:
 1. **Харицуулсан өгүүлбэрт** үйл үгийг дахин давтхаас зайлс хийхэд : **he knows more than I do.** - Тэр надаас илүү мэднэ.
 2. Эелдгээр **дэмжих, үйл дэмжихийг** хэлэхдээ **yes** болон **no** - гээр : **Do you listen to the music? Yes, we do. No we do not.**
 3. Монгол хэлний **"би ч бас", "би ч гэсэн", "би ч бас биш", "би ч гэсэн бас биш"** - ийг орчуулахад : **He reads much - so do I** - тэр их уншдаг, би ч гэсэн. **She does not read much - nor do we** - Тэр их уншдаггүй бид ч мөн адил.
 4. Монгол хэлний **"үнэн юм биш үү? үнэн биз дээ?"** гэдгийг **баталсан** өгүүлбэр болон **үгүйсгэсэн асуултанд** илэрхийлэхэд: **You feel better, do not you?** - Таны бие сайжирсан, тийм биз дээ?
Мөн **үгүйсгэсэн өгүүлбэр** болон **баталсан асуултанд** : **he didn't say so, did he?** - Тэр тэгж хэлээгүй тийм биз дээ?
гэвч эхний өгүүлбэрт **туслах үйл үг** байгаад дахин **давтагдаж байвал** : **You are not glad, are you?** - Та баярлахгүй байна, тийм биздээ?
- мөн **жирийн үйл үгийн үүргээр** (асуух болон үгүйсгэх өгүүлбэрт **to do** -гийн тусламжтай өөрчилж болдог): **He did his best** - Тэр чадах бүхнийгээ л хийсэн. **How do you do?** - Та сайн байна уу?

БАЙМЖ ҮЙЛ ҮГС (Modal verbs)

Өгүүлбэрт бие дааж хэрэглэдэггүй зөвхөн бусад үйл үгтэй нийлж утга санаа илтгэдэг үйл үгсийг баймж үйл үг гэдэг.

Одоо цаг	Өнгөрсөн цаг	Хэрэглэх	Орлуулах үйл үг
I can Би ...-ийг чадна	I could Би ...-ийг чадах байсан	<ol style="list-style-type: none"> 1. Биеийн чадвар: I can swim - би сэлж чадна 2. Оюуны чадвар: he could translate - тэр орчуулж чадах байсан 3. Боломж: can I help you? - би танд туслах уу? 	to be able to: I play chess = I'm able to play chess - би шатар тоглож чадна (үгүйсгэх үед) to be unable to - чадахгүй (зөвхөн 2-т): to know, (know to) - мэдэх
I shall Би тэгэх ёстой	I should Би тэгэх	shall: Ямар нэгэн хүнд шууд тушаал өгөх үед:	to be to

<p>(энэ нь 3 дагч этгээдийн хүслээр)</p>	<p>ёстой байсан</p>	<p>you shall not steal! - Чи хулгай хийх ёсгүй!</p> <p>should:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дам ярианд: the teacher said we should work биднийг ажиллах ёстой байсан гэж багш хэлсэн 2. Хүсэн болзох төлөв, үүрэг даалгавар: you should tell the truth - чи үнэнээ хэлэх ёстой байсан 	<ol style="list-style-type: none"> 1. Гуравдагч этгээдийн тушаал: what am I to do - би юу хийх ёстой вэ? 2. Хувь тавилан: his death was to decide her fate - түүний үхэл тэр эмэгтэйн хувь тавиланг шийдсэн 3. Цуу ярианд: to be said - to be supposed to : he is said (supposed) to be ill - түүнийг өвчтэй байх гэж хэлсэн
